

Батлав.  
“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



П.ГАНХҮҮ

**ТАВАН ТОЛГОЙ – ГАШУУН СУХАЙТ ЧИГЛЭЛИЙН 239КМ, НҮҮРС  
ТЭЭВРИЙН, ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМД ТЕХНИК АШИГЛАЛТЫН  
ТҮВШИН ТОГТООХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР**

2019.09.17

**Үндэслэл:**

Таван толгой –Гашуун сухайт чиглэлийн нүүрс тээврийн 239км нүүрс тээврийн хатуу хучилттай авто замд Техник Ашиглалтын Түвшин тогтоох үйлчилгээ авах.

**Зорилго:**

Нүүрс тээврийн тусгай зориулалтын авто замын одоогийн нөхцөл байдалд хөндлөнгийн эрх бүхий этгээдээр бодит үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж гаргуулах

Дүгнэлт, зөвлөмжид үндэслэн цаашид хийх засвар арчлалтын ажлын төрөл, дараалал, хугацааг зөв сонгох, ингэснээр замын байнгын ашиглалтын үзүүлэлтийг дээшлүүлж, өгөөжийг нэмэгдүүлэх.

**Авто замын хийц, өнөөгийн нөхцөл:**

Тус авто зам нь 2012 онд ашиглалтад орсон.  $h=0.06\text{м}$  зузаан нэг үе асфальт бетон хучилт,  $h=0.20\text{м}$  зузаан 6%-ийн цементээр бэхжүүлсэн суурь,  $h=0.20\text{м}$  зузаан зохист ширхэглэл бүхий дэд суурь,  $h=0.30\text{м}$  зузаан далангийн дээд үе, далан гэсэн хийцтэй. Зорчих хэсгийн өргөн  $b=7.5\text{м}$ , хөвөөний өргөн  $b=1.5\text{м}$ . Ашиглалтад орсноос хойш засвар арчлалтын ажлыг тогтмол хийж байгаа бөгөөд энэ хүрээнд 2017 онд 5км, 2018 онд 5км, 2019 онд 48,1км авто замд өнгө хучилт давхарлаж хучсан ба эдгээр хэсгүүдэд  $h=0.12\text{м}$  зузаан. Одоо өдөрт дунджаар 800-1000 нүүрс тээврийн авто машин зорчиж байна.

**Заавал хийх ажлын бүрэлдэхүүн:**

Тус зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Таван Толгойн нүүрсний уурхайгаас Ханбогд сумын нутаг дахь Гашуун сухайтын хилийн боомт хүртэлх 239км нүүрс тээврийн хатуу хучилттай авто замд дараах ажлын тодорхойлолтын дагуу “Техник Ашиглалтын Түвшин” (ТАТ) тогтоох үзлэгийг хийж гүйцэтгэн тайлан, дүгнэлт зөвлөмжийг захиалагчид хүлээлгэж өгнө.

Зайлшгүй хийх шаардлагатай ажлууд:

№	Ажлын нэр	Хэмжилтэнд шаардагдах багаж	Хамрах хүрээ
1	Авто замын геометр хэмжээс тодорхойлох /зорчих хэсэг, хөвөөний өргөн, хэвгий, хажуу налуу, шуудуу/	Тэгш ус, лазер тэгш ус	239км
2	Авто замын далангийн даац тодорхойлох	ДСП багаж	239км
3	Цементээр бэхжүүлсэн сууриас дээж авч бат бэх, зузаан тодорхойлох	Асфальт зүсэгч	239км
4	Асфальт бетон хучилтын бат бэхийг тодорхойлох	Бенкельманы дам нуруу	239км
5	Авто замын хучилтын тэгш бус байдлыг тодорхойлох	Бамп интегратор	239км
6	Асфальт бетон хучилтын гадаргуугийн барзгаржилт тодорхойлох	Стандарт элс, элс тараагч, сав, багс, халхавч, шугам	239км
7	Хучилтын барьцалдалтын эсэргүүцлийг тодорхойлох	Британы дүүжин багаж	239км
8	Авто замын хучилтын дугуйн мөрний ховил тодорхойлох	Металл рейк	239км
9	Авто замын ус зайлуулах хиймэл байгууламжийн бетоны эд ангид үзлэг хийх, бат бэх тодорхойлох (Щмидт-н алхаар)	Щмидтийн алх	207цэг
10	Хөрсний чийгийг тодорхойлох	Чийг хэмжигч багаж	239км
11	Авто замын тэмдэглэгээний өнгөний тодшил, ойлт тодорхойлох	-	239км
12	Авто замын тэмдэг болон тоноглолын өнгөний тодшил, ойлт тодорхойлох	-	900ш, 500ш
13	Тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргаж захиалагчид хүлээлгэж өгөх	-	Иж бүрдэл

### Онцгой нөхцөл

Гүйцэтгэх ажил дээрх жагсаалтаар хязгаарлагдахгүй бөгөөд “Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох, үнэлэх аргачлал” MNS 6441: 20014 –г үндэслэх;

Ажлын тайланд хийж гүйцэтгэсэн ажлын үе шатны зургуудыг ойлгомжтой тод авч, тайлбартайгаар хавсаргах, засвар арчлалтын оновчтой арга, технологийг санал болгох.